



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК

Тендер шалгаруулалт

гэрээний нэр:

**ГАЛЫН ДОХИОЛЛЫН НЭГДСЭН СИСТЕМ, ЦАНХИ
ХОТХОНЫ ГАЛЫН ДОХИОЛЛЫН СИСТЕМИЙН
БАТАЛГААЖУУЛАЛ, ГАЛЫН ДҮГНЭЛТ ХИЙХ АЖИЛ
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ**

Тендер шалгаруулалт

гэрээний дугаар:

ЭТТ/202001121

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Галын дохиоллын нэгдсэн систем, Цанхи хотхоны галын дохиоллын систем баталгаажуулалт, галын дүгнэлт хийх** ажил гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг **2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 00** минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 30** минутад нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Үгүй**

Сонирхсон этгээд тендертэй холбоотой бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8,
Финанс төв, 5 давхар 503 тоот
Утас: +976-7505-5555-511

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА




1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.





- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.


Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|-------------------------|--|
| ТӨӨЗ 1.1 | <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан. 2. 2018, 2019 оны аль нэг жилд ижил төстэй галын дохиоллын нэгдсэн системийн ажил гүйцэтгэж байсан туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн 1-ээс доошгүй ажлын гэрээний хуулбарыг нотариатаар гэрчлүүлэх, гэрээ дүгнэсэн акт эсвэл өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт ирүүлэх/. 3. Компанийн танилцуулга. 4. Компанийн гэрчилгээний хуулбар. 5. Татварын тодорхойлолт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендер нээх өдрийн байдлаар өргүй байх. 6. Шүүхийн төрөлжсөн архивын газрын тодорхойлолт ирүүлэх. /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ 7. ШШГЕГ-ын тодорхойлолт. /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ 8. Тендерт шалгарсан тохиолдолд ажлын даалгавар болон техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бараа нийлүүлж, ажил гүйцэтгэвэл захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх. 9. Тендерт шалгарсан тохиолдолд тендерт санал болгосон хугацаандаа бараа нийлүүлж, ажил гүйцэтгээгүй бол захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх. 10. Техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтийг хангасан бараа бүтээгдэхүүн эсэхийг нотлох баримт ирүүлэх. 11. Ажлын даалгаварт дурдагдсан ажил, үйлчилгээг үзүүлэх үеийн засварын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай зардлуудыг хариуцахыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. 12. Холбогдох инженер техникийн ажилчдын мэдээллийг жагсаалтаар ирүүлэх. 13. Үе шатны ажлын хуваарь баталгаажуулан ирүүлэх. <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай эсэх:</p> <ul style="list-style-type: none"> - Дээрх ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох тусгай зөвшөөрөлтэй байх. |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Хаяг: Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр /pdf/-ээр илгээнэ.</p> <p>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв, Утас: +976-7505-5555-511</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 5 давхар 503 тоот</p> <p>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минутад нээнэ.</p> |
| ТӨӨЗ 6.2 | <ol style="list-style-type: none"> 1. Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй |

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| № | НЭР | Хэмжих нэгж /Тоо хэмжээ/ | | ЗУРАГ | ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ |
|---|--|--------------------------|---|--|--|
| 1 | Галын дохиоллын хяналтын индикатор Станцын удирдлагын гар /С2000М/ | Ш | 1 |  | <p>Тэжээлийн хүчдэл DC,10.2...28.4В LED дэлгэцтэй Холбогдох төхөөрөмжийн тоо 127 Дэмжиж буй хэсгүүд 511 Хаягжуулах бүсийн тоо 127 Мэдээлэл дамжуулах кабелийн урт 3000м дотор Санах ой 8000 Жин 0,3кг Хэмжээ 140x114x25мм IP30</p> |
| 2 | Галын дохиоллын хүлээн авах станц /Сигнал 20П/ | Ш | 1 |  | <p>Тэжээлийн хүчдэл DC,10.2...28.4В LED дэлгэцтэй Ачааллын нийт гүйдэл 60мА ихгүй Хаягжуулах бүсийн тоо 20 Мэдээлэл дамжуулах кабелийн урт 1200м дотор Жин 0,4кг Хэмжээ 230x135x37мм</p> |
| 3 | Өргөтгөх модуль /С2000-БКИ/ | Ш | 1 |  | <p>Хяналтын LED гэрэлтэй,60 Тэжээлийн хүчдэл DC,10,2....28,4 В Хэрэглээний гүйдэл, хэвийн үед 50мА, түгшүүрийн үед 200мА Ашиглалтын температурын хүрээ, -30...+50° С Жин,0,,6 кг Хэмжээ 340x170x27,5мм IP 2</p> |

| | | | | | |
|---|----------------------------------|---|----|--|--|
| 4 | Гар мэдээлэгч /ИПР-513/ | ш | 6 |  | Тэжээлийн хүчдэл,8,,,11В Утаа мэдрэгчийн төрөл, хаягжуулдаг Гэрлийн заалт, Хүлээлгийн горим, Хяналтын LEDгэрэлтэй Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл 0,5мА Ашиглалтын температурын хүрээ,-30...+55° С Жин,0,15 кг Хэмжээ 95x91x33ммIP20 |
| 5 | Дуут дохио, гэрэл /Орос/ | ш | 8 |  | Тэжээлийн хүчдэл, 24В Дууны даралтын түвшин,105дБ Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл,0,75мА Ашиглалтын температурын хүрээ,-30...+55° С Жин,0,6 кг Хэмжээ 100x80x42ммIP55 |
| 6 | Утаа мэдрэгч /ИП-212-45/ | ш | 30 |  | Тэжээлийн хүчдэл,DC,8,,,11В Утаа мэдрэгчийн төрөл,хаягжуулдаг үй Мэдрэгчийн мэдрэмж0,05,,,0,2д Б Гэрлийн заалт,Хүлээлгийн горим, Гал Хяналтын LEDгэрэлтэй Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл,0,5мА Жин: 0,2 кг Ажиллах температур: -30...+55°С |
| 7 | Дулаан мэдрэгч /ИП-101-1А-А1/ | ш | 35 |  | Тэжээлийн хүчдэл,DC,8,,,11В Утаа мэдрэгчийн төрөл,хаягжуулдаг үй Мэдрэгчийн мэдрэмж0,05,,,0,2д Б |

| | | | | | |
|----|---|---|----------|--|--|
| | | | | | Гэрлийн заалт, Хүлээлгийн горим, Гал Хяналтын LEDгэрэлтэй Мэдрэгчийн хэрэглэх дээд гүйдэл, 0,5мА Жин: 0,2 кг Ажиллах температур: -10...+76°C |
| 8 | Тэжээлийн блок /24V,3A/ РИП-24 | ш | 2 |  | Тэжээлийн хүчдэл, АС, 150.250 В Хяналтын LEDгэрэлтэй Хэрэглээний гүйдэл 1,5А Гаралтын гүйдэл, 26,6...27,8В Гаралтын гүйдэл, 4...5А Аккумулятор, 12в 26..40Ац 2 ширхэг Ашиглалтын температурын хүрээ -10..+40°C |
| 9 | Батерэй 12В/А | ш | 4 | | Цахилгаангүй үед хэвийн горимд 24 цаг, түгшүүрийн горимд 30 минут ажиллах хүчин чадал бүхий |
| 10 | Шугамын утас 2x1.0м | м | 100 0 | | кабелиар станц руу холболт хийх, галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх |
| 11 | Холболтын хайрцаг 20P | ш | 2 | | кабелиар станц руу холболт хийх, галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх |
| 12 | Ерөнхий тэжээлийн утас 2*4см | м | 30 | | кабелиар станц руу холболт хийх, галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх |
| 13 | Утас далдлагч сувагчлалын хоолой 16мм | м | 100 0 | | , галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх |
| 14 | Тросс 8мм | м | 300 | | , галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх |

Ажил гүйцэтгэх компанид тавигдах үндсэн шаардлага:

1. Барилга хот байгуулалтын яамны тусгай зөвшөөрөлтэй.(хугацаа дуусаагүй байх)
2. Сүүлийн 1 жилд 2-аас доошгүй засвар үйлчилгээний ажил гүйцэтгэсэн гэрээтэй байх.
3. Утаа дулаан мэдрэгчийг зориулалтын багажаар шалгах чадвартай байх /heat, smoke tester/
4. Уурхайн оффис, засварын газар шинээр галын дохиоллын нэгдсэн сестимийг суурилуулах угсралтын ажлын чанартай хийж гүйцэтгэх
5. Галын дохиоллын хэвийн ажиллагаа хэрхэн хангах, ашиглалтын явцын талаар холбогдох хүмүүст сургалт хийх.
6. Засвар үйлчилгээ, ашиглалтын үед гарч болох хөнгөн эвдрэл гэмтлийг засварлах гарын авлага өгөх.

ЦАНХИ ХОТХОНЫ ГАЛЫН ДОХИОЛЛЫН СИСТЕМИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

Цанхи хотхоны галын дохиоллын нэгдсэн системийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагатай ашиглалтын гэрээг байгуулж , тухайн жилийн хугацаандаа эвдрэл гэмтэл гарсан даруй засварлуулах, хэвийн ажиллагааг хариуцан ажиллах шаардлагатай.

Гэрээний хугацаанд хийгдэх ажлууд:

1. Улиралд 1 удаа буюу жилд 4 удаагийн үзлэг үйлчилгээ хийх.
2. Гадна байрлах дуут дохионуудыг солих, бороо уснаас хамгаалсан хайрцаг хийх.
3. А-9,10,11,12 гэрүүд рүү холбосон ил утасны монтажийг далдлах.
4. Гал тогооны гар мэдээлэгч, дуут дохиог солих.
5. Гал тогооны утаа дулаан мэдрэгчид үзлэг хийж шаардлагатай мэдрэгчүүдийг солих.
6. Цанхи хотхоны амрах байр, оффисын утаа мэдрэгчид үзлэг хийж шаардлагатай мэдрэгчүүдийг солих.
7. Спорт заалны галын дохиоллын системийг цанхи хотхоны дохиоллын системтэй холбох.
8. Гэнэтийн эвдрэл гэмтэл гарч галын дохиолол ажиллахгүй тохиолдолд цаг хугацаа харгалзахгүй ирж засварлах.
9. Засвар үйлчилгээг хийсэн ажлын актыг үйлдэж холбогдох мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгөх.
- 10.Харуул хамгаалалт болон онцгой байдлын ажилтнуудад галын дохиоллын хэвийн ажиллагааг шалгах үзлэг шалгалт хийх талаар сургалт хийх.

ГАЛЫН ДҮГНЭЛТ ГАРГУУЛАХ ТУХАЙ ТАЙЛБАР

1. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн уурхайн нийт объектуудад галын дүгнэлтийг Өмнөговь аймаг ОБГазраас олгодог бөгөөд ОБГазрын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч өөрийн биеэр ирж үзлэг шалгалт хийдэг.
2. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчид “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн зүгээс үзлэг, шалгалт хийлгүүлэх тухай албан бичиг хүргүүлдэг.
3. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч нь өөрийн ажлын төлөвлөгөөгөө харгалзан цаг хугацаа товлолгүйгээр ирж үзлэг хийж дүгнэлт олгодог учир галын дүгнэлтийн захиалга хийх шаардлагагүй юм.

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна. 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. Зөрчил, гологдол арилгахгүй байх
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны ажлын хуваарь
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. Алданги
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил дуусгах
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх** 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

| | |
|----------|---|
| ГЕН 2.1 | Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Галын дохиоллын нэгдсэн систем, Цанхи хотхоны галын дохиоллын системийн баталгаажуулалт, галын дүгнэлт ЭТТ/202001121 |
| ГЕН 2.1 | Ажил нь: Өмнөговь аймгийн ОБГ-ын гамшгаас хамгаалах Улсын хяналтын байцаагчийн “Эрдэнэс таван толгой” ХК-ийн уурхайн объектууд нь галын аюулгүй байдлыг хангасан талаарх дүгнэлт гаргахад тавигдах шаардлагыг хангасан байна. Ажлын талбай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Салбар уурхай -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно. |
| ГЕН 3.1 | Төслийн менежер нь Захиалагчаас томилогдсон эрх бүхий албан тушаалтан |
| ГЕН 4.1 | Ажил эхлэх өдөр [огноо] Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр [огноо] ⁴ |
| ГЕН 7.1 | Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын [5] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана. |
| ГЕН 9.1 | Чанарын баталгаат хугацаа [тоо] хоног байна. |
| ГЕН 13.1 | Алданги ноогдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн [0.5%] байна Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн [10 хувь] байна. |
| ГЕН 17.1 | Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [огноо]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг [огноо]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна. |
| ГЕН 19.1 | Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [хувь] -иар тооцно. |

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]